



АШУУИС

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/109

Улаанбаатар хот

Анагаахын шинжлэх ухааны үндэсний
их сургуулийн Төгсөлтийн өмнөх
сургалтад оюутан элсүүлэх
журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны №А/540 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны №А/97 дугаар тушаалаар батлагдсан “Босго оноо тогтоох тухай”, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дүрмийн 4.8, 4.8.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Оюутны хөгжил, удирдлагын газрын дарга (Д.Оюунбилэг)-д, элсэгчдийн бүртгэл, хөтөлбөр сонголт, жагсаалт гаргахтай холбоотой цахим үйл ажиллагааг хариуцан ажиллахыг Цахим хөгжил, маркетингийн газрын дарга (С.Энхболд)-д, элсэлтийн санхүүгийн бүртгэл, төлбөр тооцоотой холбоотой үйл ажиллагааг хариуцан ажиллахыг Санхүү, эдийн засгийн газрын дарга (Э.Содномжамц) нарт тус тус даалгасугай.

3.Элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Багшийн хөгжил цахим сургалтын газрын дарга, Элсэлтийн комиссын дарга (Г.Батбаатар)-д үүрэг болгосугай.

2023.04.26

4.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны №А/97 дугаар тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн №А/99 дүгээр тушаалаар батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”, 2023 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн №А/47 дугаар тушаалын хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Б.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАХИРАЛ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the text "МОНГОЛЫН УЛАМ" at the top, "МОНГОЛЫН УЛАМ" at the bottom, and "УАД1007*58454" at the very bottom. The signature is a large, stylized cursive mark.

Н.ХҮРЭЛБААТАР

Анагаахын шинжлэх ухааны үндэсний-их сургуулийн
Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн
А/109 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



АШУУИС-ИЙН ТӨГСӨЛТИЙН ӨМНӨХ СУРГАЛТАД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн (цаашид АШУУИС гэх) Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэхэд Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2022 оны А/540 дүгээр тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2023 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан "Босго оноо тогтоох тухай" болон энэхүү журмыг баримтална.
- 1.2. Элсэлтийн үйл ажиллагааг ил тод, шударга зохион байгуулна.
- 1.3. АШУУИС-ийн элсэлтийн элсэлтийн журам, суралцах хөтөлбөр, ЭЕШ-ын оноо тооцох болон элсэлттэй холбоотой бусад мэдээллийг www.mnum.edu.mn цахим хуудсанд байршуулна.
- 1.4. Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх оюутны хяналтын тоог АШУУИС -ийн саналыг үндэслэн Удирдах зөвлөл тогтооно.
- 1.5. Засгийн газар хоорондын болон АШУУИС-тай хамтын ажиллагааны гэрээний дагуу суралцах гадаад иргэдийг АШУУИС-ийн захирлын тушаалаар шууд элсүүлэн суралцуулж болно.
- 1.6. Удирдах зөвлөлөөс батласан хяналтын тоонд багтаан элсэлтийн үйл ажиллагааг жилд 2 удаа зохион байгуулж болно.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС

- 2.1. АШУУИС-ийн Захирлын тушаалаар батлагдсан Элсэлтийн комисс нь элсэлттэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, комиссын гишүүдийн ажил үүргийг хуваарилах, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, журмаар зохицуулаагүй асуудлыг хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2.2. Элсэлтийн комиссын дарга нь Боловсрол хариуцсан дэд захирал, нарийн бичгийн дарга нь Оюутны хөгжил, удирдлагын газрын дарга, гишүүдэд Оюутны хөгжил, удирдлагын газар болон Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газрын арга зүйч, мэргэжилтнүүд, Санхүү, эдийн засгийн газар, Цахим хөгжил, Маркетингийн газрын инженер, мэргэжилтэн нар байна.

ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1. АШУУИС-д элсэх хүсэлт гаргасан байх.
- 3.2. Бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой байх;
- 3.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын (ЭЕШ) Боловсролын Үнэлгээний Төвийн (БҮТ) хүчин төгөлдөр батламжтай эсвэл гадаадын улс орны ерөнхий боловсролын шалгалтын оноог БҮТ-өөр дүйцүүлсэн батламжтай байх;
- 3.4. Тухайн хөтөлбөрт шаардагдах хичээлээр ЭЕШ-ын үндэсний хэмжээний босго оноог хангасан байх;

ДӨРӨВ. ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

4.1. АШУҮИС-д элсэх хүсэлтээ elselt.mnnums.edu.mn элсэлтийн бүртгэл, мэдээллийн цахим системээр гаргах ба тухайн жилийн 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн бүртгэлийн систем нээгдэж, ЭЕШ-ын дүн нийтэд зарлагдсан сүүлийн өдрийн 18.00 цаг хүртэл бүртгүүлнэ.

4.2. Хүсэлт гаргахдаа элсэлтийн бүртгэл, мэдээллийн цахим системд шаардлагатай мэдээллээ оруулах ба дутуу, алдаатай мэдээлэл оруулснаас гарах сөрөг үр дагаврыг АШУҮИС хариуцахгүй болно.

ТАВ. ХӨТӨЛБӨР СОНГОХ, ЭЛСЭГЧДИЙГ ШАЛГАРУУЛАХ

5.1. Элсэгч нь ЭЕШ-ын дүн нийтэд зарлагдсан өдрөөс хойш 72 цагийн дотор элсэх хөтөлбөрөө эрэмбэлж, дараалуулж сонгоно.

5.2. Элсэгч нь хөтөлбөр сонголтын хураамжаа цахимаар төлснөөр баталгаажих бөгөөд төлбөрийг буцаан олгохгүй.

5.3. Элсэгчид нь ЭЕШ өгсөн тухайн хот, орон нутаг дахь хяналтын тоонд онооны жагсаалтаар өрсөлдөнө.

5.4. Хөтөлбөр сонголт дууссанаас хойш 24 цагт багтаан хөтөлбөр сонголтын дүнг ЭЕШ-ын хичээлийн нийлбэр онооны дарааллаар, жагсаан нийтэд нээлттэй мэдээлнэ.

5.5. Элсэгчдийн ЭЕШ-ын хэмжээст онооны нийлбэр тэнцсэн тохиолдолд онооны хувь болон бүрэн дунд боловсролын үнэмлэхийн үнэлгээний дундаж хувийг харьцуулж шийдвэрлэнэ.

5.6. Элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноо хангасан АШУҮИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн төгсөгчдийг тухайн жилийн хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

5.7. Тогтоосон хугацаанд хөтөлбөр сонголт болон баталгаажуулалтаа хийгээгүй бол элсэхээс татгалзсанд тооцно.

ЗУРГАА. СУРАЛЦАХ ЭРХ ОЛГОХ

6.1. Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч нь 48 цагийн дотор сургалтын төлбөр төлж, анкет бөглөн, "АШУҮИС-д оюутан суралцуулах гэрээ"-г Оюутны хөгжил, удирдлагын газартай байгуулснаар суралцах эрх баталгаажна.

ДОЛОО. ЭЛСЭГЧДИЙГ БҮРТГЭХ

7.1. Элсэгчдийн бүртгэл тухайн хичээлийн жилийн 8 дугаар сарын 3 дахь долоо хоногт нээгдэнэ. Элсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж, цахимаар бүртгүүлнэ. Үүнд:

- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол тухайн баримт бичиг)
- Сурагчийн хувийн хэрэг
- ЭЕШ-ын батламж
- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг
- Сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5 хэмжээтэй цээж зураг
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан баримт

7.2. Бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн, бүрдүүлсэн тохиолдолд бүртгэлээс хасах бөгөөд хариуцлагыг элсэгч өөрөө хүлээнэ.

НАЙМ. ГАДААД ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

8.1. Төгсөлтийн өмнөх сургалтад суралцах гадаадын иргэн жил бүрийн 04 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 15-ны хооронд хүсэлтээ цахимаар гаргана.

8.2. Гадаад иргэн нь АШУУИС-ийн вэб хуудсанд байршуулсан өргөдлийн маягт, эрүүл мэндийн хуудсыг бөглөж, дараах баримтын хамт илгээнэ.

- Гадаад иргэний үнэмлэх (Identification card), гадаад паспорт болон түүнтэй адилтгах бичиг баримт (хүчинтэй хугацаа 3-аас дээш жил)
- Боловсролын түвшинг илтгэх диплом (гэрчилгээ), дүнгийн хавсралтыг англи эсвэл монгол хэлрүү орчуулсан орчуулгын хамт
- Англи хэлний мэдлэг, чадварыг илтгэх (TOEFL, IELTS, TOEIC зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх) баримт, монгол хэлээр суралцах бол монгол хэлний шалгалтын дүн
- Цээж зураг (3.5x4.5 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авахуулсан байх)
- Эрүүл мэндийн хуудас (сэтгэцийн эмчийн дүгнэлт, HIV, HBV, HCV, TPNA, TB шинжилгээнд сүүлийн 3 сар дотор хамрагдсан байх)

8.3. Суралцах хүсэлт гаргасан гадаад иргэнд ажлын 10 хоногт багтаан хариуг холбогдох хаягаар хүргүүлнэ.

8.4. Суралцах эрх авсан гадаадын иргэн тухайн хичээлийн жил эхлэхээс 14 хоногийн өмнө дараах материалыг эх хувиар авчирч бүртгүүлнэ. Үүнд:

- Гадаад иргэний үнэмлэх (Identification card), гадаад паспорт болон түүнтэй адилтгах бичиг баримт (хүчинтэй хугацаа 3-аас дээш жил)
- Боловсролын түвшинг илтгэх диплом (гэрчилгээ), дүнгийн хавсралт
- Англи хэлний мэдлэг, чадварыг илтгэх (TOEFL, IELTS, TOEIC зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх) баримт, монгол хэлээр суралцах бол монгол хэлний шалгалтын дүн
- Цээж зураг (3.5x4.5 хэмжээтэй, сүүлийн 3 сарын дотор авахуулсан байх)
- Эрүүл мэндийн хуудас (сэтгэцийн эмчийн дүгнэлт, HIV, HBV, HCV, TPNA, TB шинжилгээнд сүүлийн 3 сар дотор хамрагдсан байх)
- Амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамрагдсан баримт (Монгол улсын даатгалд заавал хамрагдсан байх)
- Бүртгэлийн хураамж төлсөн баримт (тухайн өдрийн Монгол банкны ханшаар байх)

ЕС. БУСАД

9.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэн дараах тохиолдолд ЭЕШ-гүй элсүүлэн суралцуулж болно.

9.1.1. Дээд боловсролтой буюу дипломын голч дүн 2.8 ба түүнээс дээш бол,

9.1.2. Дипломын боловсролтой иргэн мэргэжлийн чиглэлийн дагуу шаталсан бакалаврын хөтөлбөрт элсэх бол,

9.1.3. Бакалаврын болон техникийн боловсрол эзэмшсэн иргэн дипломын хөтөлбөрт элсэх бол,

9.2. Тодорхой мэргэжлийн хөтөлбөрт нэмэлт элсэлтийг хяналтын тоонд багтаан хот, орон нутаг харгалзахгүйгээр ЭЕШ-ын оноогоор жагсаан элсүүлнэ.

9.3. Ур чадварын шалгалтын хэлбэрийг элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

9.4. АШУУИС-ийн оюутан элсүүлэх шаардлагыг хангаагүй боловч хичээл сонгон судлах хүсэлт гаргасан иргэнийг "Иргэнээр суралцагч" гэж бүртгэж болно.

9.4.1. Иргэнээр суралцагч нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэн байх ба тухайн хичээлийн жилд 42 хүртэл багц цагийн хичээлийг судалж болно.

9.4.2. Иргэнээр суралцагч нь оюутны хөгжлийн зээл болон буцалтгүй тусламжид хамрагдах боломжгүй.

9.4.3. Иргэнээр суралцагч нь тус журмын гуравдугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд "Оюутан"-аар бүртгэж, үргэлжлүүлэн суралцуулна.

9.4.4. Иргэнээр суралцагч нь "Оюутан" -аар бүртгэгдсэн өдрөөс эхлэн холбогдох дүрэм, журмын дагуу оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдах эрх нээгдэнэ.

9.6. Элсэгчдэд тавих шаардлагыг хангасан элсэгчдийг АШУҮИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.

9.7. Шинэ элсэгчдийн удиртгал хичээлийг 8 дугаар сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулна.

9.8. Шинээр элссэн оюутнуудыг АШУҮИС-ийн төв эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулна

9.9. АШУҮИС-ийн оюутан элсүүлэх шаардлагыг хангасан тусгай хэрэгцээт иргэн холбогдох хууль, тогтоол, журамд заасны дагуу сургалтын төлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах боломжтой болно.

9.10. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан журамд нийцүүлэн элсэлтийг авна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн
Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн
А.1109 дугаар тушаалын 02 дугаар хавсралт

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн
Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх
хөтөлбөрийн жагсаалт

Элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор жагсаан сонгох хөтөлбөр

Бакалаврын хөтөлбөрийн жагсаалт:

1. Хүний их эмч
2. Уламжлалт анагаахын их эмч
3. Шүдний их эмч
4. Био-Анагаах судлаач
5. Нийгмийн эрүүл мэнд судлалч
6. Эм зүйч
7. Хүүхдийн их эмч
8. Зүү төөнө заслын эмч
9. Эрүүл ахуй, тархвар судлалч

Элсэлтийн босго оноо ханган шууд элсүүлэх хөтөлбөр

Бакалаврын хөтөлбөрийн жагсаалт:

1. Эрүүл мэндийн мэдээлэл зүйч
2. Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
3. Уламжлалт анагаахын засалч
4. Сувилагч (бакалавр)
5. Эх баригч (бакалавр)
6. Хөдөлгөөн засалч
7. Хөдөлмөр засалч
8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйч
9. Эрүүл мэндийн хоол зүйч
10. Эрүүл мэндийн эдийн засагч

Дипломын хөтөлбөрийн жагсаалт:

1. Дүрс оношилгооны техникч
2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн угсралт, ашиглалтын техникч, электроникч
3. Нүүр амны техникч
4. Нүүр амны эрүүл ахуйч
5. Эм найруулагч
6. Уламжлалт анагаахын сувилагч
7. Сувилагч (диплом)
8. Лабораторийн техникч
9. Эх баригч (диплом)